



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/685

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өсөх ирээдүйн зам” ХХК (РД:2106701)-ийн Булган сум 5 дугаар баг Л.Энэбиш 2 дугаар гудамж 221а тоотод байршилтай 6308001325 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1700 м.кв газрын газар эзэмших эрхийг Н.Батзориг (ГЭ87010510)-т 12 жилийн хугацаатай, иргэн С.Ганбаяр (ГЙ79101810)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 11 дүгээр гудамж 1108в тоотод байршилтай 6308009559 нэгж талбар бүхий амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 315 м.кв газрын газар эзэмших эрхийг Б.Сэлэнгэ (ГИ87040500)-д 7 жилийн хугацаатай тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2 Н.Батзориг, Б.Сэлэнгэ нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2007 оны 132 дугаар захирамжийг, Аймгийн Засаг даргын 2024 оны А/112 дугаар захирамжийн С.Ганбаяртай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР